

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/069/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbataart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.14 № 01/60

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.ЭНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн ой санамжийг бий болгох, төр иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрийн бүртгэлийн үйлчилгээгээр иргэний эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,754,903.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,749,874.8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 5,028.2 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд улсын бүртгэл мэдээлэл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 зорилт, 29 арга хэмжээний хэрэгжилт 95.75 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 99.1 хувь байна.

41250115

G/Архив/Alban bichig 2025/ A4

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,288,399.34</u>	<u>136,852,902.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	614,385.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	614,385.30
3121	Төгрөг	00.00	614,385.30
31211	Төрийн сангийн харилцах	00.00	614,385.30
33	АВЛАГА	34,423.58	85,500,000.00
335	Бусад авлага	34,423.58	85,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	34,423.58	85,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,253,975.76	50,738,516.86
351	Түүхий эд материал	13,025,875.76	26,718,696.86
35110	Тусгай зориулалттай материал	13,025,875.76	26,718,696.86
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,554,315.00	4,556,185.00
354	Хангамжийн материал	18,673,785.00	19,463,635.00
35410	Бичиг хэргийн материал	2,019,150.00	1,964,970.00
35420	Аж ахуйн материал	8,594,360.00	9,122,990.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,086,000.00	1,511,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,974,275.00	6,864,675.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>860,138,371.97</u>	<u>804,902,550.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	860,138,371.97	804,902,550.11
392	Биет хөрөнгө	847,688,371.97	792,452,550.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	688,700,983.00	688,700,983.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,043,811.30	-51,652,573.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,040,563.00	71,040,563.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,827,376.50	-71,040,563.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	359,656,737.56	355,523,341.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-188,209,948.30	-219,789,536.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,024,775.92	80,087,035.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,695,218.47	-60,458,366.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,500,000.00	2,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,458,332.94	-2,458,332.94
393	Биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,450,000.00	12,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>896,426,771.31</u>	<u>941,755,452.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>614,385.30</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	614,385.30
4136	Бусад өглөг	00.00	614,385.30
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	614,385.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>896,426,771.31</u>	<u>941,141,066.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	896,426,771.31	941,141,066.97

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,213,991.97	190,213,991.97
51101	Өмч: - төрийн	177,763,991.97	177,763,991.97
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12,450,000.00	12,450,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	706,212,779.34	750,927,075.00
51210	Өмнөх үеийн үр дүн	706,212,779.34	706,212,779.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	44,714,295.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>896,426,771.31</u>	<u>941,755,452.27</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,194,585,084.40	2,184,453,753.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,473,053.40	51,739,204.17
120	Нийтлэг татварын бус орлого	45,473,053.40	51,739,204.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,160,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,160,000.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,829,283.40	4,365,924.17
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	23,483,770.00	47,373,280.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,149,112,031.00	2,132,714,549.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,084,216,000.00	1,754,903,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,084,216,000.00	1,754,903,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,896,031.00	377,811,449.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,706,031.00	212,708,249.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,190,000.00	165,103,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,246,110,149.03	2,139,739,457.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,246,110,149.03	2,139,739,457.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,243,571,700.18	1,910,295,445.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,113,476.19	1,393,026,628.90
210101	Үндсэн цалин	594,286,511.27	724,877,785.01
210102	Нэмэгдэл	259,234,822.42	512,218,424.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,003,742.50	149,250,419.05
210104	Урамшуулал	20,588,400.00	6,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,893,947.33	188,132,651.42
210201	Тэтгэврийн даатгал	81,539,534.21	133,445,506.85
210202	Тэтгэмжийн даатгал	9,429,465.13	13,718,688.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,543,611.67	7,015,038.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,852,747.67	6,788,300.90
210205	Эрүүл мэндийн даатгал	18,528,588.65	27,165,116.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,416,406.05	44,844,561.69
210301	Гэрэл, цахилгаан	2,690,874.05	2,918,820.37

210302	Түлш, халаалт	36,771,338.00	40,056,687.32
210303	Цэвэр, бохир ус	1,954,194.00	1,869,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,799,379.00	28,527,335.00
210401	Бичиг хэрэг	11,964,610.00	17,240,930.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	4,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,505,084.00	2,736,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,829,685.00	3,149,485.00
210408	Бараа материал ақталсны зардал	-	560,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,531,210.00	942,280.00
210604	Урсгал засвар	5,531,210.00	942,280.00
2107	Томилолт, зочны зардал	-	180,000.00
210702	Дотоод албан томилолт	-	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,866,421.90	29,185,789.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,933,000.00	1,223,445.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	99,846.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,933,421.90	27,862,498.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,950,859.71	225,456,198.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,190,000.00	161,384,452.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,470,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,010,859.71	62,601,746.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,538,448.85	229,444,012.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	224,415,770.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	220,881,770.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	3,534,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,038,448.85	5,028,242.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,038,364.95	5,028,235.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	83.90	6.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(51,525,064.63)	44,714,295.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,215,349.99	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	19,215,349.99	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(19,215,349.99)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(70,740,414.62)	44,714,295.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,433,731,602.62	2,428,746,327.57
11	ТАТВАРЫН ОРЛОГО	284,619,571.62	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	284,619,571.62	-
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	284,619,571.62	-
118001	Улсын тэмдэгтийн хураамж	284,619,571.62	-

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	381,531,778.57
120	Нийтлэг татварын бус орлого	-	381,531,778.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	381,531,778.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	381,531,778.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,149,112,031.00	2,047,214,549.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,084,216,000.00	1,754,903,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,084,216,000.00	1,754,903,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,896,031.00	292,311,449.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,706,031.00	127,208,249.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,190,000.00	165,103,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,432,392,102.62</u>	<u>2,425,131,942.27</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,432,392,102.62	2,425,131,942.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,144,833,882.15	1,814,770,536.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,151,904.00	1,392,938,964.00
210101	Үндсэн цалин	594,324,939.08	724,790,120.11
210102	Нэмэгдэл	259,234,822.42	512,218,424.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,003,742.50	149,250,419.05
210104	Урамшуулал	20,588,400.00	6,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,889,943.10	188,132,651.42
210201	Тэтгэврийн даатгал	81,535,529.98	133,445,506.85
210202	Тэтгэмжийн даатгал	9,429,465.13	13,718,688.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,543,611.67	7,015,038.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,852,747.67	6,788,300.90
210205	Эрүүл мэндийн даатгал	18,528,588.65	27,165,116.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,416,406.05	44,844,561.69
210301	Гэрэл, цахилгаан	2,690,874.05	2,918,820.37
210302	Түлш, халаалт	36,771,338.00	40,056,687.32
210303	Цэвэр, бохир ус	1,954,194.00	1,869,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,916,489.00	18,775,375.00
210401	Бичиг хэрэг	12,171,700.00	10,780,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,505,084.00	2,736,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,739,705.00	2,568,955.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,586,140.00	1,920,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	738,980.00	940,000.00
210604	Урсгал засвар	5,847,160.00	980,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	180,000.00
210702	Дотоод албан томилолт	-	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,933,000.00	1,405,791.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,933,000.00	1,305,945.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	99,846.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,940,000.00	166,573,193.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,190,000.00	165,103,193.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,470,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	287,558,220.47	610,361,405.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	224,415,770.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	220,881,770.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	3,534,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	266,969,660.80	347,363,124.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,393,213.64	5,028,235.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	83.90	6.49
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	263,576,363.26	342,334,881.63
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,088,559.67	38,582,511.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,088,559.67	38,582,511.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,339,500.00	3,614,385.30
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,739,700.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,739,700.00	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,739,700.00	3,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,739,700.00	3,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,739,700.00)	(3,000,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(400,200.00)	614,385.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	400,200.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	614,385.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	776,953,193.96	-	967,167,185.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,213,991.97	-	776,953,193.96	-	967,167,185.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(70,740,414.62)	-	(70,740,414.62)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	706,212,779.34	-	896,426,771.31
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	706,212,779.34	-	896,426,771.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,213,991.97	-	706,212,779.34	-	896,426,771.31

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	44,714,295.66	-	44,714,295.66
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,213,991.97	-	750,927,075.00	-	941,141,066.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,754,903,100.00	1,749,874,864.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,754,903,100.00	1,749,874,864.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,530,487,200.00	1,525,459,094.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,282,531,700.00	1,282,531,700.00
210101	Үндсэн цалин	682,194,000.00	724,790,120.11
210102	Нэмэгдэл	422,777,700.00	401,811,160.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,380,000.00	149,250,419.05
210104	Урамшуулал	17,180,000.00	6,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,683,500.00	174,331,666.42
210201	Тэтгэврийн даатгал	127,066,800.00	124,076,346.83
210202	Тэтгэмжийн даатгал	11,904,200.00	12,613,795.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,952,100.00	6,462,585.46
210204	Ажилгүйдлийн даатгал	5,952,100.00	6,235,847.80
210205	Эрүүл мэндийн даатгал	23,808,300.00	24,943,090.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,140,000.00	44,844,561.69
210301	Гэрэл, цахилгаан	3,640,000.00	2,918,820.37
210302	Түлш, халаалт	40,500,000.00	40,056,687.32
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	1,869,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,767,000.00	18,775,375.00
210401	Бичиг хэрэг	10,780,000.00	10,780,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,450,000.00	2,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,352,000.00	2,736,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	245,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,940,000.00	2,568,955.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,900,000.00	1,920,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	940,000.00	940,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	980,000.00	-
210604	Урсгал засвар	980,000.00	980,000.00
2107	Томилолт, зочны зардал	245,000.00	180,000.00
210702	Дотоод албан томилолт	245,000.00	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	1,750,000.00	1,405,791.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	1,450,000.00	1,305,945.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	99,846.00
210807	Газрын төлбөр	200,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,470,000.00	1,470,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,470,000.00	1,470,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,415,900.00	224,415,770.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	224,415,900.00	224,415,770.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	220,881,900.00	220,881,770.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,534,000.00	3,534,000.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,754,663,100.00	2,136,434,878.57
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,754,663,100.00	1,749,874,864.11
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,754,903,100.00	1,749,874,864.11
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	614,385.30
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48	45
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	39	34
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	3	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,896,031.00	289,311,449.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,896,031.00	289,311,449.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,895,947.10	289,311,442.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,738,604.00	110,407,264.00
210102	Нэмэгдэл	47,738,604.00	110,407,264.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,967,343.10	13,800,985.00
210201	Тэтгэврийн даатгал	4,057,842.73	9,384,631.00
210202	Тэтгэмжийн даатгал	477,386.64	1,104,087.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	381,909.30	552,053.00
210204	Ажилгүйдлийн даатгал	95,427.33	552,053.00
210205	Эрүүл мэндийн даатгал	954,777.10	2,208,161.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	-
210604	Урсгал засвар	3,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,190,000.00	165,103,193.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,190,000.00	165,103,193.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83.90	6.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	83.90	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	83.90	6.49
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	83.90	6.49
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,896,031.00	295,311,449.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,896,031.00	295,311,449.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,706,031.00	130,208,249.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,190,000.00	165,103,200.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, олон улсын жишигт нийцсэн улсын бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэхийн тулд улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд үндэслэн төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх, улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх чиг үүрэг бүхий Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, хэрэгжүүлэх 29 арга хэмжээтэй баталснаас нийт 95.75%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь захиргааны аж ахуйн нэгж, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг, иргэний бүртгэлийн тасаг гэсэн бүтэц, зохион байгуулалттай ба тайлант онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, улсын ахлах бүртгэгч 2, улсын бүртгэгч 31, үйлчилгээний ажилтан 5, гэрээтээр 5 бүгд 45 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Орон тооны бус дотоод хяналт шалгалтын хороог шинэчлэн байгуулах тухай" А/02 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод хяналт шалгалтын хороо нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 3 чиглэлээр 9 арга хэмжээг улирал, хагас, бүтэн жилээр төлөвлөн байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, санхүү, бүртгэлийн болон өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын дотоод хяналтын хороо хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, шилэн дансны хөтлөлт, архивын үйл ажиллагаа, цаг ашиглалт, аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулан ажилласан бөгөөд ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тусгасан болно.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хадгалалт хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал, талархлын бүртгэл, шийдвэрлэлт гэсэн 3 үндсэн чиглэлээр хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2020 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн Хууль зүйн дотоод хэргийн сайдын А/87 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба улсын бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохирсон тусдаа бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,328.7 мянган төгрөгөөр буюу 5,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	614.4	614.4
Авлага	34.4	85,500.0	85,465.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,254.0	50,738.5	14,484.5
Үндсэн хөрөнгө	860,138.4	804,902.6	(55,235.8)
Нийт хөрөнгө	896,426.8	941,755.5	45,328.7
Өр төлбөр	-	614.4	614.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	896,426.8	941,141.1	44,714.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	896,426.8	941,755.5	45,328.7

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 13,693.0 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 1,870.0 мянган төгрөг, аж ахуйн материал 528,630.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 54,180.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 109,600.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2024 онд акталсан 21,962.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд орон нутгийн хөрөнгөөр 3,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 4,891.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 941,141.0 мянган төгрөг болж 44,714.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,395,434.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Улсын бүртгэлийн газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 4,157.1 мянган төгрөгөөр бууруулж 2024 оны урсгал зардлын төсвийг 1,391,277.7 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,391,277.7 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 1,754,903.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,754,903.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 5,028.2 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,749,874.8 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70406 /Улсын бүртгэл, мэдээлэл/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2024.01.01 2024.12.31	Улсын бүртгэл, мэдээлэл-Үндсэн үйл ажиллагааны зардал	95.75%	1,530,487.20	1,525,459.09
2	70406 /Улсын бүртгэл, мэдээлэл/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2024.01.01 2024.12.31	Улсын бүртгэл, мэдээлэл-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		224,415.90	224,415.80
	Дүн				1,754,903.10	1,749,874.89

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн зардалд 165,103.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас орон нутгийн цалингийн нэмэгдэлд 127,208.2 мянган төгрөг, Зуунмод сумын Засаг даргын тамгын газраас 3,000.0 мянган төгрөг, нийт 295,311.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 124,208.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 165,103.2 мянган төгрөг, нийт 289,311.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70406	2024.01.01-2024.12.31	Улсын бүртгэл, мэдээлэл	Хөтөлбөр 95.75 %	1,754,903.1	1,749,874.8

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь батлагдсан төсвийг бүрэн зарцуулж хөтөлбөрийг хэрэгжүүлэн, үнэлгээгээрээ 2-р байрт шалгарч ажилласан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 44,440.0 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар, 30,417.0 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, нийт 74,857.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 70,277.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан нь зарим худалдан авалтууд хийгдээгүйтэй холбоотой байна.

3.5.6 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Тус хэлтэс нь 2024 онд улсын төсвийн орлогод нийт 260,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 342,334.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 132 хувьтай байна. Өмнөх онд нийт 240,000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 363,576.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 150 хувьтай байна. Орлогын төлөвлөгөө өмнөх оноос 20,000.0 мянган төгрөгөөр өссөн, гүйцэтгэл 21,241.4 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5.7 Судалгааны үр дүн

Тус хэлтэс нь тайлант онд ахмадын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний данс /210801/-ны хувьд 1,305.9 мянган төгрөгийг үндсэн санхүүжилтийн данснаас зориулалтын дагуу зарцуулсан байна. Бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын хувьд нэмэлт санхүүжилтийн данснаас Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн зардалд 165,103.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Орон тооны хувьд төрийн захиргааны 40, төрийн үйлчилгээний 5, гэрээт 3, нийт 48 орон тоо батлагдсан байхад гүйцэтгэлээр төрийн захиргааны 35, төрийн үйлчилгээний 5, гэрээт 5, нийт 45 орон тоотойгоор ажилласан нь гэрээт ажилтны тоог 2-оор хэтрүүлсэн байна. Уг зөрчилд зөвлөмж өгч хүргүүлсэн болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 27/139 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлага 1,432,392.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,485.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,114.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус хэлтэст тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд цалингийн

зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 19 орлогын, 53 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 6 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллагад 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст дараагийн аудитаар цалингийн бичилт, ХХОАТ-ын тохируулгын тайлан, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зөрүүг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 289,404.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний журналд 199,571.5 мянган төгрөгийн 11 ширхэг ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичиж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Аймгийн Засаг даргын 2024 оны А/780 дугаар захирамжаар тус хэлтэст нягтруулсан шүүгээ худалдан авахад зориулж 85.5 сая төгрөгийг хуваарилсныг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Оны эцсийн бараа материалын дансны үлдэгдэлд 3,294.7 мянган төгрөгийн хасах дүнтэй бараа материалыг тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Оны эцсийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэлд 568.6 мянган төгрөгийн хасах дүнтэй үлдэх өртөгтэй хөрөнгийг тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үндсэн цалин үзүүлэлтийн төлөвлөгөө 270.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэл 200.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөж, үлдэх өртөггүй болсон 236 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохдоо нэмэгдлүүдийг тооцохгүй зөвхөн үндсэн цалингийн зөрүүг тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зөрүүг зөв тооцоолж олгох.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан хаагчдын цалингаас суутгасан ХХОАТ-ын зөрүүг тохируулаагүй, тохируулгын тайланг хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жил бүрийн эцэст ХХОАТ-ын тохируулгын тайланг хийж хөнгөлөлтийг зөв тооцож тайлагнах.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

УБЕГ-ын даргын 2019 оны Б/178 дугаар тушаалаар гэрээт албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 3-аар баталсан байхад орон тоог хэтрүүлэн 5-аар ажиллуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээт албан хаагчдыг орон тооны батлагдсан дээд хязгаарт багтаан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	5	289,404.9	1	85,500.0	4	203,904.9	5	289,404.9				
Дүн	5	289,404.9	1	85,500.0	4	203,904.9	5	289,404.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн дахин үнэлээгүй.	1	0.0					1	0.0
Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн зөрүүг зөрүүтэй тооцсон.	1	0.0					1	0.0
ХХОАТ-ын зөрүүг тохируулаагүй тохируулгын тайланг хийгээгүй байна.	1	0.0					1	0.0
Гэрээт ажилчдын орон тоог хэтрүүлэн ажиллуулсан байна.	1	0.0					1	0.0
Дүн	4	0.0					4	0.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn